



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,  
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ  
Б.ДАВААЖАВ ТАНАА

2017. 02. 23 № 3/289  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

### Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Үйлдвэр урлалын политехник коллежийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

**Аудитынтайлан**

**Үндэсний аудитын газар:**

1.САГ-ын дарга, Тэргүүлэх

аудитор: Ц.Наранчимэг

Утас:

2.Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 260512

**“Нью Эстимэйтэр Аудит” ХХК:**

1.Захирал Ж.Үхэрбат

Утас: 99117097

2.Ахлах аудитор Д.Баяраа

Утас: 99359981

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хаяг: УБ хот ЧД, Ж.Самбуу-22

“Зоос гоёл” №213

## **АГУУЛГА:**

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуу ~~зүүлэлт~~, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

## **1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 -т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/93 тушаалаар батлагдсан 47/2016 тоот “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-ний дагуу Үйлдвэрлэл урлал политехник коллежийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланда аудит хийлээ.

Аудитыг Җөсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуунэн зөв, шударга ил эрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмуу ~~Җөсвийн~~ байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС -тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн төсвийн 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрлын аудитыг 2016 оны 10 дугаар сараас эхэлж, жилийн эцсийн санхүүгийн тайланд 2017 оны 01 дүгээр сарын 27-ноос 02 дугаар сарын 21-ний хооронд хийхээр төлөвлөн компанийн захирал Ж.Үхэрттар, ахлах аудитор Д.Баяраа, аудитор Ү.Алтанзул нар гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-А-9/

Үйлдвэрлэл урлал политехник коллеж нь төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 1дүгээр сарын 24-ний өдрийн 2/28 тоот албан бичгээр “Нью Эстимэйттор Аудит” ХХК-д ирүүлсэн.

“Нью Эстимэйттор Аудит” ХХК нь аудитыг Җөсвийн тухай хууль болон аудитыг хийх төлөвлөгөө, хөтөлбөрт заасан хугацаанд тус тус багтаан Үндэсний аудитын газраар хянуулж, аудитын тайландаа Үйлдвэрлэл урлал политехник коллежийн удирдлагад гардуулна.

## **2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн өсвийн захирагч нь Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсролын тухай хууль, бусад хууль, Засгийн газрын тогтоол, салбарын Сайдын гаргасан тушаал шийдвэр болон бусад нийтлэг заавар, журмын төрдөж үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Тус сургууль нь зорилгоо “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчдын шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх” гэж тодорхойлсон байна.

Байгууллагын бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “төсвийн байгууллагань түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга тухайн байгууллагын т шууд захирагч байна” гэжзаасанбайна.

Үйлдвэрлэл урлалийн политехник коллежийн 2016 болны төсвийн санхүүжилтийг Хөдөлмөр Нийгмийн хамгаалалын яамнаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрхзүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой төсвийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үйлдвэрлэл урлалийн политехник коллежийн үйл ажиллагааны талаар/ТАБ-СТА-А-1/ маягтад тодорхой тусгасан.

### **4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, бусад хууль, тогтоол, заавар, журмыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Үйлдвэрлэл урлал политехник коллежийн төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын үзээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 11-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Үйлдвэрлэл урлал политехник коллежийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/218 дугаар тушаалаар Хөдөлмөрийн салбарын хэмжээнд мөрдөгдөх “Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталж мөрдөнажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлгийн Бараа, материалын бүртгэлийн Нэг заалтыг эс тооцвол УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бodoх бүртгэлийн програм нийцсэнбайна.

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн

технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагааг гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

### **5. Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гараахаас хамгаалахын тулд жилийн түршнөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

### **6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2016 оны батлагдсан ёсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн ёсвийн шууд захирагч нь 2016 онд улсын ФСВӨӨС урсгал зардлыг санхүүжүүлэхээр 1,738.2сая төгрөгийг баталснаас гүйцэтгэлээр 1,736.6 сая төгрөгийг олгосон нь 1,6 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Мөн Сайдын багцаас 120,0 сая төгрөг, Мэргэжлийн боловсролыг дэмжих сангаас суралцагчдын тэтгэлэгт 63,5 сая төгрөг, Мэргэжлийн боловсролын салбарын чуулга уулзалтанд оролцогсдын хоолны зардалд 2,2сая төгрөг, 2015 оны татан төвлөрүүлтээс буцаан авсан авлага 1,8 сая төгрөг нийт 187,5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт /орлого/-ыг авсан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогод 310,0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогод 92.0 сая төгрөгийн орлого нийт 402,0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсанаас Үндсэн үйл ажиллагааны орлогын хувьд гүйцэтгэлээр 329,1 сая төгрөгийг, туслах үйл ажиллагааны орлогод 47,7 сая төгрөг нийт 376,8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн зарцуулсан байна. Актлагдсан үндсэн хөрөнгө борлуулж 1,4 сая төгрөгийн мөнгөн орлого олсон байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардалд 2,140.3сая төгрөг батлагдсанаас урсгал зардалд 2,095.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 16,7 сая төгрөгийг тус тус зарцуулж, батлагдсан ёсвийг 27, 5сая төгрөгөөр хэмнэсэн гэж тайлагнагдсан байна.

Харин мөнгөн бус орлогын хувьд **а)** цалингийн суутгалаархи орлогоор 3,5 сая төгрөг, **б)** Гадаадын зээл тусламжаар 1,708.2сая төгрөгийн үндсэн хөрөнгө болон бараа хүлээн авч орлогоор тооцож тус тусын холбогдох дансанд бүртгэж санхүүгийн тайланд тайлагнасан байна.

### **7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуух бмэдээллийг оруулсан байна. Тус мэдээллийг <http://www.shilendans.gov.mn/org/1499> холбоосоор мэдээлэл авахыг үссэн этгээд авч болно. Үндсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээг 1 -12 сараарөссөн дүнгээр , хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээг 1-12 сараар тус тус гаргасан байна.

## **8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын өлөвлөгөөний дагуу аудитын 35 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Урсгал зардалд батлагдсан ёсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэсэн, зарим зардлын төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй, ТГТ, МГТ-үүд хоорондоо зөрүүтэй тайлагнагдсан, кассын анхан шатны зарим баримтын бүрдүүлэлт дутуу зэрэг өрчлүүд нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдлүүд нь хөрөнгийн захиран зарцуулалтын эрхийг хэтрүүлэх, төсвийг хяналтгүй зарцуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

## **9. Материаллаг байдлын түвшинг сонгосон үндэслэл:**

Материаллаг түвшний хувьд нийт орлого, нийт болон цэвэр жөрөнг ийн дүн нь тус тус өндөр гарч байгаа тул бага дүнтэй нийт зардлаас материаллаг байдлын түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт зардлын 1%-иарбуу 34,8 сая төгрөг байхаар тогтоов.

## **10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн өсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудынэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, санхүүжилт, нэмэлт санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, түрээсийн тооцоо, торгууль, шимтгэлийн орлого, өглөг, авлагын тооцоо, тогтмол зардлын тооцоо, ХАОАТ, НДШ-ийн тооцоо үлдэгдэл, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, хоолны тооцоо, нормын хувцас зөөлөн эдлэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, 1 удаагийн тэтгэлэг, нэмэгдэл, сургалт семинар, хичээл дадлагын зардал зэрэг дансанд ажил үйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

/ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт санхүүжилт, орлогын 99,9 хувь, мөнгөн хөрөнгийн 53 хувь, нийт зардлын 35,3 хувь /2015 оны санхүүгийн аудитаар цалингийн зардалд нарийчилсан гориймтгэсэн тул энэ аудитад хийгдээгүй/, нийт жөрөнгийн 100 хувь, нийтөр төлбөрийн 100 хувийг тус тус эзэлж байна.

## **11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 06 -ны өдрийн А/218 дугаар тушаалаар баталсаард Хөдөлмөрийн салбарын "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлгийн 4.3 дахь Бараа, материалын бүртгэлийн 4.3.4 -т "Нэг жилээс ишүү 3 жилээс бага ашиглалтын

хугацаатай хөрөнгийг Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс хэмээн хүлээн зөвшөөрч бараа материалын дансны үзүүлэгт Хангамжийн материал гэсэн хэсэгт бүртгэж болно"-гэж заасан нь дараах стандарт, заавар, журмыг зөрчсөн байна. Үүнд::

- Улсын Секторын Нягтлан Бодох Үргэлийн Олон Улсын Стандарт /УСНББОУС 17/ "Үндсэн хөрөнгө"-ийн 17.3-т "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм"-гэж заасан байна.
- Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27 -ны өдрийн 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын НББ -ийн дансны заавар"-ын 4.29-д "Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг НББ-ийг УСНББОУС17 "Үндсэн хөрөнгө"-ийг дагаж мөрдөнө"-гэж
- Мөн тушаалын 4.15-д "Бараа материалыг ангилж үргэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө."- гэсэн;
- УСНББОУС 12 "Бараа, материал"-ын 12-т Улсын секторын бараа материалд дараах үзүүлэлт багтана - гэсний дагуу 12(г)-д "Үндсэн Хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн стандартад авч үзсэнээс бусад барилга байгууламж болон тоног өхөөрөмжид ашиглах зорилготой нөөц, сэлбэг" гэж хүлээн зөвшөөрөхөөр заасан байна.

Иймд Хөдөлмөрийн салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлгийн 4.3 дахь Бараа, материалын бүртгэлийн 4.3.4 дахь заалтыг эргэн харах, залруулах шаардлагатай байна. /салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа болно./

**Шийдвэрлэсэн:** Байгууллагад Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яаманд Нягтлан бодох үргэлийн бодлогын баримт бичгийг УСНББОУС болон үүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журамтай нийцүүлж өгөх талаар асуудлыг тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг өгөх

**2.** Батлагдсан төсөвт зардлаас хичээл, дадлагатай холбогдуулан 6,0 сая төгрөгийн ном, оёдлын машин гэсэн үндсэн хөрөнгийг худалдан авсан нь дараахь хууль, журмыг зөрчсөн байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"-гэсэн;
- Сангийн сайдын баталсан 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журам"-ын 8 дугаар зүйлийн 8.1 -д "Төсвийн байгууллага нь олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулахаас өөр бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно."-гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Урсгал зардалд батлагдсан төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаартус тус зөвлөмж өгөх.

**3.** Тус байгууллагын 2016 оны өсөвт өөрийн орлогын эх үүсвэрийг: 1) үндсэн үйл ажиллагааны орлого болох суралцагчдаас авах мэргүүлэх сургалтын төлбөрт 310,0 сая өгрөгөөр, 2) туслах үйл ажиллагааны орлогод цайны газар, ТҮЦ-ийн түрээс 5,6 сая төгрөг, дотуур байрны төлбөрт 70,0 сая төгрөг, БАЗТ-ийн орлого 16,4 сая төгрөг нийт 92,0 сая өгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэн зарцуулахаар баталсан байна.

Аудитаар үндсэн болон туслах орлогын гүйлгээг тулган шалгахад:

-Үндсэн үйл ажиллагааны орлого 329,1 сая төвлөрүүлсэн нь батлагдсан төсвөөс 19,0 сая төгрөг буюу 6%-иар илүү төвлөрүүлсэн байна.

-Туслах үйл ажиллагааны орлогын хувьд нийт 92,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 47,7 сая төгрөгийг төвлөрүүлж гүйцэтгэл 52%-тай байна. Тухайлбал:

1. Бүсийн арга зүйн төлбөрийн орлого /багшлах эрхийн төлбөр/-ыг 16,4 сая төгрөгөөр баталсан. Гүйцэтгэлээр 30,2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2. Дотуур байрны өлбөрийн орлого 70,0 сая төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 14,6 сая төгрөг болж 55,4 сая төгрөг буюу 79,1 %-иар дутуу төвлөрүүлсэн байна.

Дотуур байрныөлбөр дутуу төвлөрүүлсэн шалтгаан ы Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн 8/190 тоот албан бичигт суралцагчийн дотуур байрныөлбөрийг авахгүй байх тухай заасан албан бичгийг ирүүлсэн тул төлбөрийг зогсоосон байна.

Мөн дотуур байрны суралцагчдаас төлбөр авч байгаа нь дараахь хуулийн заалтуудтай нийцэхгүй байна.

- Боловсролын тухай хуулийн 40 үзүүлэлтийн 40.2 -т "Төрийн өмчит ... мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны нийт зардал ... улсын төсвөөс санхүүжүүлнэ." –гэсэн;
- Хуулийн 43.2.2-т "өрөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрандлбөргүй суух." – гэсэн;.

**Шийдвэрлэсэн:** Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яаманд төсвийн төлөвлөлт, батлуулахтай холбоотой асуудлыг тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг өгөх

## **12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

## **13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Үйлдвэрлэл уралын политехник коллежийн төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар ажиллагсадын цалин, нийгмийн даатгал, татвартай холбоотой зардлыг авчүзэх. /2015 оны санхүүгийн аудитаар нарийвчилсан горим гүйцэтгэсэн. 2016 оны аудитаар хойшлуулсан./

## **14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн иэгтгэл:**

Үйлдвэрлэл уралын политехник коллежийн төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 6,0 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба үүнээс 6,0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

## **15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төсвийн шууд захирагчийн төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 10 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээрээс 1 зөвлөмж нь гаднын хүчин зүйлсээс шалтгаалан биелэгдээгүй ба зөвлөмжийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.

## **16. Зөрчилгүй санал дүгнэлт**

Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, үүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна..

Аудитлагдсан санхүүгийн тайлан ..... хуудас, хавсралтууд хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.



**YAG**  
УНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛ ПОЛИТЕХНИК  
КОЛЛЕЖИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН**

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах  
хаягаар харилцана уу:**

**Үндэсний аудитын газар:**

1.САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор:  
Ц.Наранчимэг  
Утас:

2.Аудитын менежер: Я.Самбууням  
Утас: 260512

**“Нью Эстимэйтэр Аудит” ХХК:**

1.Захирал Ж.Үхэртэр  
Утас: 99117097

2.Ахлах аудитор Д.Баяраа  
Утас: 99359981

**Аудитынтайлан**

Асуудал 1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын  
баримт бичгийн талаар**3**

Асуудал 2: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу  
зарцуулах талаар **4**

Асуудал 3: Хууль, дүрэм, журмын хэрэгжилтийн  
талаар**5**

Хаяг: УБ хот ЧД, Ж.Самбуу-22  
“Зоос гоёл” №213

## **Менежментийн захидал**

“Нью Эстимэйтор Аудит” ХХК нь аудитын явцад илрүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Уйлдвэрлэл урлалын политехник коллежийн удирдлагад зориулж бэлтгэсэн ёөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэ~~УАГ~~-ын аудитын горимоос урган гарсан болно. Сайхгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Уйлдвэрлэл урлалын политехник коллежийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

“Нью Эстимэйтор Аудит” ХХК-ын зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан Өгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлаа хийж гүйцэтгэлээ. Аудитын явцад шаардлагатай баримт материалыг цаг хугацаандаа гаргажгч, шаардлагатай мэдээллээр биднийг хангаж байсныг сайшаан тэмдэглэж байна.

Та бүхэн энэхүү менежментийн захидалтай уншиж танилцан бидэнд хариугаа ирүүлнэ үү. Танай хариутай танилцануучай тайлагналын талаарх ойлголтоо баталгаажуулсны дараа бид аудитын дүгнэлтээ хүргүүлэх болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Уйлдвэрлэл урлалын политехник коллежийн удирдлага болон ажилтнуудад талархал илэрхийлье.

**Ажиглалт:**

Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/218 дугаар тушаалаар баталсанөдөхмөрийн салбарын "Нягтлан бодох үргэлийн бодлогын баримт бичгийн 4үгдэр бүлгийн 4.3 дахь Бараа, материалын бүртгэлийн 4.3.4-т "Нэг жилээс илүү 3 жилээс бага ашиглалтын хугацаатайрэнгийг Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс хэмээн хүлээн зөвшөөрч бараа материалын дансны бүлэгт Хангамжийн материал гэсэн хэсгүүдээж болно" -гэж заасан нь дараах стандарт, заавар, журамтай нийцэхгүй байна. Үүнд::

- Улсын Секторын Нягтлан Бодохрүүгэлийн Олон Улсын Стандарт /УСНББОУС 17/ 'Үндсэн хөрөнгө"-ийн 17.3-т "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм"-гэж заасан байна.
- Сангийн сайдын 2006 оны 11 үгээр сарын 27 -ны өдрийн 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын НББ-ийн дансны заавар"-ын 4.29-д Үйдсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансныүнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг НББ-ийг УСНББОУС17 Үндсэн хөрөнгө"-ийг дагаж мөрдөнө"-гэж
- Мөн тушаалын 4.15-д "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө."- гэсэн;
- УСНББОУС 12 "Бараа, материал"-ын 12-т Улсын секторын бараа материалыд дараахүйлс багтана- гэсний дагуу 12(г)-д Үндсэн Хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн стандартад ажсэнээс бусад барилга байгууламж болон тоног өхөөрөмжид ашиглах зорилготой нөөц, сэлбэг" гэж тус тус хүлээн зөвшөөрөхөөр заасан байдаг байна.

**Эрсдэл:**

НББ-ийн бодлогын баримт бичиг нь санхийн тайлан бэлтгэж, толилуулахын тулдүүрүүгээ хөтлөлтөд ашиглах бүртгэлийн суурийг тодорхойлсон, нийтлэг өрдөх хууль, стандарт, дүрэм, журамд нийцсэн заавар аргачлалын дагуу бүртгэл хөтлөх практик үйл ажиллагааг тодорхойлсон удирдамж тул санхийн тайлан, толилуулгыг буруу гаргах эрсдэлтэй.

**Зөвлөмж:**

Байгууллагад Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яаманд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг УСНББОУС болон үүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журамтай нийцүүлж өгөх талаар асуудлыг тавьж шийдвэрл зөвлөмжийг өгөх.

**Үйлчлүүлэгчийн хариу:**

Илэрсэн алдааг асуудлынүүртгэлээр танилцуулан баталгаажуулсан болно.

2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 1/21 тоот албан бичгээр зөвшөөрсөн тухай хариуг авсан..

**Асуудал-2. Батлагдсан төсвийг  
зориулалтын дагуу зарцуулах**

**Тэргүүлэх ач холбогдол 2**

**Ажиглалт:**

Урсгал зардалд батлагдсан төсвөөр х ичээл, үйлдвэрлэлийн дадлагатай холбогдуулан 6071,9 мянган төгрөгийн ном, оёдлын машин гэсэн үндсэн хөрөнгийг худалдан авсан нь дараах хууль, журмын заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"-гэсэн;
- Сангийн сайдын баталсан 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журам"-ын 8 дугаар үйзийн 8.1 -д ӨСБийн байгууллага нь олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулахаар бусад өтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно."-гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Эрсдэл :**

Урсгал зардалд батлагдсан төсвөөст үндсэнхөрөнгө хөрөнгө бэлтгэхгүй байх. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаар тус тус зөвлөмж өгөх зарцуулах талаар тус тус зөвлөмж өгөх

**Зөвлөмж:**

Урсгал зардалд батлагдсан төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаар тус тус зөвлөмж өгөх.

**Үйлчлүүлэгчийн хариу:**

Илэрсэн алдааг асуулж тээвэрб танилцуулан баталгаажуулсан болно. 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 1/21 тоот албан бичгээр зөвшөөрсөн тухай хариуг авсан.

## БАЙГУУЛЛАГЫН НЭР: ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕ

0

## 2016 ОНЫ АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	Эхний улдэгдэл	Эцсийн улдэгдэл	Аудитласан-Эхний улдэгдэл	Аудитласан- Эцсийн улдэгдэл	0	0
